



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

**Ковид-19 түргэвчилсэн оношлуур хуваарилах
тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 47 дугаар зүйлийн 47.1.3, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 05/А/12 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2021 оны А/64, А/79 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед шинжилгээ хийх түргэвчилсэн оношлуурыг оношлуурын нөөцгүй болсон сумдад хуваарилсан хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилсан түргэвчилсэн оношлуурыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын сэжигтэй тохиолдол болон халдварын голомтот бүс нутгаас ирсэн иргэдэд оношилгоо хийх зорилгоор зарцуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмын дагуу хөрөнгийн бүртгэлд авч, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тариалан сумын Намнангийн арын хяналтын пост болон Зооноз өвчин судлалын төвд байрлах шинжилгээний цэгүүдэд Эрүүл мэндийн газарт хуваарилагдсан оношлуураар хангаж түгээн, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн тархвар судлал хариуцсан мэргэжилтэн (Д.Өлзийсайхан), Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн (М.Мөнх-Аюуш) нарт үүрэг болгосугай.

4. Оношлуурыг хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад шуурхай хүргүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Ахлах нягтлан бодогч (М.Мягмарсүрэн)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (М.Энхдалай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.ҮҮРИЙНБАЯР

D:\HP\tushaal\2020-a.docx

35110103

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
03 дүгээр сарын 16-ны өдрийн А./25 дугаар
тушаалын хавсралт



КОВИД-19 ОНОШЛУУРЫН ХУВААРИЛАЛТ

№	Сумдын нэр	Оношлуур		
		Тоо /ширхэг/	Үнэ	Нийт үнэ
1	Арбулаг	10	20,000	200,000
2	Бүрэнтогтох	61	20,000	1,220,000
3	Галт	50	20,000	1,000,000
4	Жаргалант	50	20,000	1,000,000
5	Рашаант	50	20,000	1,000,000
6	Тариалан	100	20,000	2,000,000
7	Төмөрбулаг	50	20,000	1,000,000
8	Цагаан-Уул	50	20,000	1,000,000
9	Цэцэрлэг	50	20,000	1,000,000
10	Цагаан-Үүр	50	20,000	1,000,000
11	Чандмань-Өндөр	25	20,000	500,000
12	Далайн-Элбэрэлт	50	20,000	1,000,000
13	Энэрэл	50	20,000	1,000,000
14	Энх-Үйлс	50	20,000	1,000,000
15	Энх-Үрс хүүхдийн эмнэлэг	25	20,000	500,000
16	Эрүүл мэндийн газар /Намнангийн пост, Зооноз өвчин судлалын төв шинжилгээний цэг/	329	20,000	6,580,000
Нийт дүн		1050	20,000	21,000,000